

“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХУВЬЦААТ КОМПАНИ

2026 оны 3-р сарын 20 өдөр

Дугаар: 26/03

Улаанбаатар хот

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-нд

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлах тухай

Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 4-р сарын 30-ны өдрийн 11 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Сөүлийн гудамж, Сити Плаза 2 давхарт 202а тоот өрөөнд болно.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр: 2026 оны 4-р сарын 10 өдөр.

Хавсралт, /... хуудас

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Р.САИДАБРОР

“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК **ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН** **ТОГТООЛ**

2026 оны 3 сарын 18 өдөр

Дугаар: 26/01/02

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйл, 64.2 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журмын 2.1 , 2.3 дахь заалтууд, компанийн дүрмийн холбогдох заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Фронтинер Лэнд Групп” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 4-р сарын 30-ны өдрийн 11 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Сөүлийн гудамж, Сити Плаза 2 давхарт 202а тоот өрөөнд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 4-р сарын 10 өдрөөр тогтоосугай.
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
 2. Компанийн 2026 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
 3. Ногдол ашиг хувиарлах эсэх тухай тайлагнах
 4. “Морьт Импекс” ХХК-тай байгуулах гэрээг дүгнэх, шаардлагатай арга хэмжээг авах
 5. Бусад
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2026 оны 3-р сарын 23-нд өдөр тутмын сонин, радио телевизийн аль нэгээр болон МХБ-ийн сайтаар; 2026 оны 4-р сарын 10-нд уг зарыг давтан, 2026 оны 3-р сарын 28-ны дотор брокерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.
5. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2026 оны 4-р сарын 28-ны өдрийн 10 цагаар тасалбар болгосугай.
6. Ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ны агуулгыг Хавсралт 1-р, хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хавсралт 2-р, хурлын дэгийг Хавсралт 3-р тус тус баталсугай.
7. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг 2026 оны 4-р сарын 01 өдөр гэхэд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс /Р.Отгонбат/-т даалгасугай.
8. Хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргэхтэй холбогдон гарах зардлыг компаниас гаргуулсугай.

9. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Р.Отгонбат, гишүүнээр, Д.Батсайхан, Тооллогын комиссийн даргаар Д.Чулуунбаатар, гишүүнээр Д.Бямбасүрэн нарыг тус тус томилсугай.
10. “Фронттиер Лэнд Групп”ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг Санхүүгийн Зохицуулах Хороо, “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-д хүргүүлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.Машбат

Д.МАШБАТ

**“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК -ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
АНХААРАЛД**

“Фронтитер Лэнд Групп” ХК -ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 4-р сарын 30-ны өдрийн 11 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Сөүлийн гудамж, Сити Плаза 2 давхарт 202а тоот өрөөнд болно.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр: 2026 оны 4-р сарын 10-ны өдөр. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2026 оны 4-р сарын 28-ны өдрийн 10 цаг.

Хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Компанийн 2026 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
3. Ногдол ашиг хувиарлах эсэх тухай тайлагнах
4. “Морьт Импекс” ХХК-тай байгуулах гэрээг дүгнэх, шаардлагатай арга хэмжээг авах
5. Бусад

Хурлын материал, гарах шийдвэрийн төсөл болон холбогдох бичиг баримттай 2026 оны 4-р сарын 01-ний өдрөөс хойш ажлын өдрүүдэд 09⁰⁰-17⁰⁰ цагийн хооронд дараах хаягаар ирж танилцах боломжтой.

Хурал зохион байгуулах комиссын дарга: Р.Отгонбат, гишүүнээр, Д.Батсайхан,
Тооллогын комиссийн даргаар Д.Чулуунбаатар, гишүүнээр Д.Бямбасүрэн

Утас: 99105646

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Сөүлийн гудамж, Сити Плаза 2 давхарт 202а тоот

**Хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн танилцах
бичиг баримтын жагсаалт**

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;
2. Компанийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө;
3. Бусад

Хурлын материал, гарах шийдвэрийн төсөл болон холбогдох бичиг баримттай 2026 оны 4-р сарын 01-ний өдрөөс хойш ажлын өдрүүдэд 09⁰⁰-17⁰⁰ цагийн хооронд дараах компанийн хаягаар ирж танилцах боломжтой.

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Сөүлийн гудамж, Сити Плаза 2 давхарт 202а тоот өрөө

Утас: 99105646

И-мэйл: batsaikhan.dugarsuren@mdr.mn

**“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС**

“Фронттиер Лэнд Групп” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 4-р сарын 30-ны өдрийн 11 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Сөүлийн гудамж, Сити Плаза 2 давхарт 202а тоот өрөөнд болно.

Хувьцаа эзэмшигчийн овог: нэр:

Регистрийн дугаар:,

Санал өгөх хувьцааны тоо:

Бүртгэсэн:

/Үнэт цаасны компанийн нэр/

Брокерийн овог: нэр:

№	Санал өгөх асуудал	Зөвш өөрсө н	Татга лзсан	Түтгэ лсэн
1	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах			
2	Компанийн 2026 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах			
3	Ногдол ашиг хувиарлах эсэх тухай тайлагнах			
4	“Морьт Импекс” ХХК-тай байгуулах гэрээг дүгнэх, шаардлагатай арга хэмжээг авах			
5	Бусад			

Брокер /гарын үсэг, тамга/

Хувьцаа эзэмшигч /гарын үсэг/

Санал авах хуудсыг ашиглах санамж

1. Засварласан, балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
2. Хувьцаа эзэмшигч өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол зуучлагч брокерийн пүүс дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгнө.
3. Хэрэв саналаа өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүний овог нэр, хаягийг дор бичих бөгөөд өөрийн санал авах хуудас, иргэний үнэмлэх, хувьцаа эзэмшиж буй баталгаа болон даалгаврын гэрээний хамт өгч явуулна.

Таныг төлөөлөх хүний овог: нэр:

Оршин байгаа газрын хаяг:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаар 99105646 утсаар лавлаж болно.

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон шалтгаан:.....

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа /минут/
1.	Хувьцаа эзэмшигчид хурлын танхимд цуглах, ирц бүртгэх /ажлын хэсэг/	15
2.	Хурлын ирцыг мэдээлэх /ажлын хэсэг/	3
3.	Хурлын дарга хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээж хурлаар хэлэлцэх асуудлууд хурлын дэгийг танилцуулна	10
4.	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлуудыг дараалалын дагуу танилцуулан асуудал тус бүр дээр санал аван санал шүүмжлэлийг сонсох	45
5.	Хурлын завсарлага	5
6.	Тооллогын комиссын дүн болон тогтоолыг уншиж танилцуулах	5
7.	Хурлаас гарах хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр тогтоолыг уншиж танилцуулах	10
8.	Хурлын дарга хурлыг хаах	3
9.	Бусад	5

Хурал зохион байгуулах комисс

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын нэгдүгээр хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	“Фронттиер Лэнд Групп” ХК
Хаяг, утас:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Сөүлийн гудамж, Сити Плаза 2 давхарт 202а тоот өрөөнд Утас: +(976) 99105646
Хурал хуралдах өдөр, цаг:	2026 оны 4-р сарын 30-ны өдөр 11.00 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Сөүлийн гудамж, Сити Плаза 2 давхарт 202а тоот өрөө
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	ТУЗ
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2026 оны 3-р сарын 18-ны өдөр
Олон нийтэд зарлах огноо:	2026 оны 3-р сарын 23 болон 4-р сарын 10-ны өдөр
Бүртгэлийн өдөр:	2026 оны 4-р сарын 10-ны өдөр
Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо:	2026 оны 3-р сарын 28-ны дотор
Хүргүүлсэн огноо:	2026 оны 3-р сарын 19 өдөр
Хурлын даргын нэр:	Р.Отгонбат
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Тооллогын комиссийн даргаар Д.Чулуунбаатар, гишүүнээр Д.Бямбасүрэн
Баримт, бичгийн жагсаалт /хавсралтаар/:	Албан бичиг, Хурал хуралдуулах ТУЗ-ийн тогтоол, Зарын загвар, Саналын хуудасны загвар, Хурлаар танилцах бичиг баримтын жагсаалт, Хурлын дэг.
Баримт, бичгийн хуудасны тоо:	 хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОММИССЫН ДАРГА

..... /...../

2026 оны 3-р сарын 19-ний өдөр

Дээрх мэдээллийг, хавсралт материалын хамт 2 хувь үйлдээж Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад тус тус ирүүлнэ.

“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП”

ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ

ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 3-р сарын 16 өдөр

Улаанбаатар хот

“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК– ийн төлөөлөн удирлах зөвлөлийн хурал 2025 оны 3-р сарын 16 өдөр 17 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Сөүлийн гудамж, Сити Плаза 2 давхарт 202а тоот өрөөнд эхлэв.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд 7 гишүүн биеэр оролцсон болно. Хурлыг Гүйцэтгэх Захирал Сайдаброр Рустамходжаев нээв.

Гүйцэтгэх Захирал Сайдаброр Рустамходжаев: ТУЗ-ийн гишүүд та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Компанийн тухай хуулийн 59.4 заалтын дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах шаардлагатай байна.

ТУЗ-ийн гишүүд: Дэмжиж байна.

“Фронтинер Лэнд Групп” ХК -ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 4-р сарын 30-ны өдрийн 11 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Сөүлийн гудамж, Сити Плаза 2 давхарт 202а тоот өрөөнд хуралдуулъя.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр: 2026 оны 4-р сарын 10-ны өдөр байх юм. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2026 оны 4-р сарын 28-ны өдрийн 10 цаг. Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэх саналтай байна. Үүнд:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Компанийн 2026 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
3. Ногдол ашиг хувиарлах эсэх тухай тайлагнах
4. “Морьт Импекс” ХХК-тай байгуулах гэрээг дүгнэх, шаардлагатай арга хэмжээг авах
5. Бусад

Бид 2026 оны 4-р сарын 01-ний өдөр гэхэд хувьцаа эзэмшигчдийн танилцвал зохих материалыг бэлэн болгоно Хурлын материал, гарах шийдвэрийн төсөл болон холбогдох бичиг баримттай ажлын өдрүүдэд 09⁰⁰-17⁰⁰ цагийн хооронд компанийн хаягаар ирж танилцах боломжтой гэж тусгая.

Хурал зохион байгуулах комисс, хурлын дарга: Р.Отгонбат, гишүүнээр, Д.Батсайхан, Тооллогын комиссийн даргаар Д.Чулуунбаатар, гишүүнээр Д.Бямбасүрэн нарыг томилох саналтай байна

ТУЗ-ийн гишүүд: Дэмжиж байна.

Гүйцэтгэх Захирал Сайдаброр Рустамходжаев: Хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргэхтэй холбогдон гарах зардлыг компаниас гаргана.

ТУЗ-ийн гишүүд: Дэмжиж байна. Ийнхүү ээлжит ТУЗ-ийн хурал 18 цаг 30 минутад дуусав.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
ХУРЛЫН ДАРГА:

А.Амирлан
Д.Машбат

“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 4-р сарын 30 өдөр

Дугаар:

Улаанбаатар хот

/төсөл/

ТАЙЛАН, ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9 заалт, 2026 оны 4-р сарын 30-ны өдрийн тооллогын комиссын ... дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бизнес төлөвлөгөө болон компанийн үйл ажиллагааг цаашид хэвийн явуулахад шаардлагатай бусад төсөл төлөвлөгөөг батлан зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

Р.ОТГОНБАТ

“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 4-р сарын 30 өдөр

Дугаар:

Улаанбаатар хот

/төсөл/

**НОГДОЛ АШИГ ХУВИАРЛАХГҮЙ
ТУХАЙ ШИЙДВЭРИЙГ ТАЙЛАГНАХ НЬ**

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.6-р заалтууд, 2026 оны 4-р сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын ... дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Тус компани нь ногдол ашиг хувиарлахгүй гэж шийдвэрлэсэн тухай болон түүний үндэслэл, тайлбарыг хувьцаа эзэмшигч нарт тайлагнасан болохыг дурьдсугай.

ХУРЛЫН ДАРГА

Р.ОТГОНБАТ